

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.9.1 Мөнгөн хөрөнгө	8
2.9.2 Авлага.....	9
2.9.3 Урьдчилгаа	9
2.9.4 Бараа материал	10
2.9.5 Нөөцийн бараа	10
2.9.6 Үндсэн хөрөнгө	11
2.9.7 ӨР ТӨЛБӨР	12
2.9.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО.....	12
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.12. Шилэн дансны мэдээлэл	13
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Менежментийн захидал.....	14
3.1 төсвийн зарцуулалттай холбоотой асуудал	14
3.2 төсвийн зарцуулалттай холбоотой асуудал	14
3.3 харьяа газуудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал.....	15
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	21
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс

1. Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.25 № 01/935
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2020\0325SAG11.Docx

001051681

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature] О.ТЭНГИС

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0325SAG11.Docx

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Т.Бадрал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, төсвийн зарцуулалтад, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 05-наас 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж, гэрээт аудитор Н.Нямсүрэн нар гүйцэтгэв.

Онцгой байдлын ерөнхий газар 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 9/477 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

АЛСЫН ХАРАА: Үндэсний болон олон улсын хэмжээнд итгэл хүлээсэн, үйл ажиллагааны чадавхтай байгууллага болон хөгжихөд оршино.

ЭРХЭМ ЗОРИЛГО: Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Иргэн, хуулийн этгээд байгууллагын алба хаагчдыг гамшгаас хамгаалах чиглэлээр сургах сургалт дадлагыг зохион байгуулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, үнэлэх, эрсдэлийн үнэлгээг хийлгэх /хуулийн этгээд байгууллага/, гамшгаас хамгаалах чиглэлээр мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилт тавин хэрэгжүүлж ажиллажээ.

Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Онцгой байдлын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 оноос хойш холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль, журам мөрдөгдөхгүй байх зэрэг үр дагавартай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хэрэгжилттэй танилцахад Төв болон орон нутгийн Онцгой байдлын харьяа 8 байгууллагын 2018 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гарган, зөвлөмж өгч, 5 байгууллагын өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг шалгаж, дүнг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадралд илтгэх хуудсаар тухай бүр танилцуулсан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд 2019 оны 2/218 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Онцгой байдлын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 123,079.1 сая төгрөгийн 2 хувь буюу 2,461.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж, хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 38 байгууллагын 41 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 39 санхүүгийн тайлан аудитад хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлсэн, улсын нууцын зэрэглэлтэй 1 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан 30 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллагуудын 7 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 11,495.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 9,700.5 сая төгрөгийн 23 алдааг аудитын явцад залруулж, 68.3 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,205.6 сая төгрөгийн 24 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 520.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 68 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын явцад дараах алдаануудыг залруулан ажилласан. Үүнд:

- Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалт, их засварын санхүүгийн тайлангийн барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа 277.2 сая төгрөгийн өглөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 420.1 сая төгрөг, Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар 36.4 сая төгрөг, Нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлангаар 8.8 сая төгрөг, нийт 465.3 сая төгрөгийн устгах бичилт хийгээгүй санхүүгийн тайланг илүү дүнгээр нэгтгэсэн байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Улсын нөөцийн объект 3 нь ажилтанд олгосон хоол, унааны нөхөн олговор 32.6 сая төгрөгийг татварт тайлагнаагүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан 2006 оны Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3. "Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ" гэж заасныг, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 "Суутгагч нь энэ хуулийн 8.1.7, 8.1.8, 11 дүгээр зүйл, 13.1.2-13.1.4, 14.1.1, 15 дугаар зүйлд заасны дагуу суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд ирүүлнэ", 2019 оны Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/15 дугаар тушаалаар нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй гал унтраах тусгай зориулалтын автомашин, үүргийн гал унтраагуур, үлээгч аппарат зэрэг 4 нэр төрлийн 572.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Дотоод хэргийн их сургуульд ашиглуулахаар хүлээлгэн өгсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Төрийн байгууллага, албан газар ... нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй:" 2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 13.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгахаар өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,134.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,958.0 сая төгрөгийн 21 алдааг аудитын явцад залруулж, 68.3 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 600.4 сая төгрөгийн 22 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 507.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 66 зөвлөмжийг хүргүүллээ.

2.9 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.9.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 244.0 сая, эцсийн үлдэгдэл 363.7 сая төгрөг болж, 119.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	4.8	0.2	- 4.6
Банканд байгаа бэлэн мөнгө	239.2	363.5	124.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Хадгаламж	0.0	0.0	0.0
Дүн	244.0	363.7	119.7

Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансанд хөрөнгө оруулалтын барьцаа 301.3 сая, ахмадын сангийн үлдэгдэл 60.6 сая, нийт 361.9 сая, Давтан сургалт, сэргээн заслын төв ТӨҮГ-ын арилжааны банкин дахь харилцах дансанд 1.6 сая, кассад 0.2 сая төгрөг, бүгд 363.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Тус агентлагийн Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг зурж төсвийг захиран зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д "дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна", 16.4.5-д "агентлагийн дарга тус агентлагийн төсвийн" гэж заасантай нийцээгүй;
- Ховд аймгийн Онцгой байдлын хэлтэс тайлант онд төрийн сангийн хянаж баталгаажуулсан цалингийн төлбөрийн хүсэлтийг сольж, ажилчдын цалинг 66.9 сая төгрөгөөр дутуу олгосон байна. Дутуу олгосон 66.9 сая төгрөгийг урсгал засварт 54.9 сая, гишүүнчлэлийн төлбөрт 1.2 сая, түлш болон ажилчдын четон худалдан авахад зориулж 10.9 сая төгрөгийг зарцуулсан;
- Онцгой байдлын ерөнхий газар тусгай зориулалтын тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээ үзүүлэх 25 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан 5,553.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээс чанарын баталгааны барьцаа 184.7 сая төгрөгийг суутгаагүй олгосон;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг зөрчин 162.0 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгосон; */Говь-Алтай аймгийн ОБХ 59.6 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 37.4 сая, Үндэсний аврах бригад 40.6 сая, Сүхбаатар аймгийн ОБХ 12.0 сая, Баянхонгор аймгийн ОБХ 0.7 сая, Архангай аймгийн ОБХ 7.9 сая, Дорноговь аймгийн ОБХ 0.9 сая, Хэнтий аймгийн ОБХ 2.9 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ОБХ/*
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг зөрчин 59.5 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн; */Төв аймгийн ОБХ 38.0 сая, Орхон аймгийн ОБХ 21.5 сая төгрөг/*
- Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийг зөрчин 38.9 сая төгрөгийн хандив авсан; */Баян-Өлгий аймгийн ОБХ 20.1 сая, Ховд аймгийн ОБХ 18.8 сая төгрөг/*
- Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс анхан шатны баримтын бүрдэлгүй 29.3 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн;
- Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг зөрчин 10.6 сая төгрөгийг зарцуулсан; */Нийслэлийн онцгой байдлын газар 4.0 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 3.2 сая, Үндэсний аврах бригад 3.4 сая төгрөг/*
- Дундговь аймгийн онцгой байдлын хэлтэс төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдардаг 23 албан хаагчид нийт 5.7 сая төгрөгийн түлш халаалтын хөнгөлөлт олгосон;

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 4,338.9 сая, эцсийн үлдэгдэл 11,290.6 сая төгрөг болж, 6,951.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	20.6	17.8	- 2.8
Татаас, санхүүжилтийн авлага	780.3	45.1	- 735.2
Бусад авлага	3,538.0	11,227.7	7,689.7
Дүн	4,338.9	11,290.6	6,951.7

Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 167 дугаар тогтоолоор газар тариалан эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хаврын тариалалтад зориулж улсын нөөцийн салбаруудаас үрийн улаан буудай зээлээр олгосон. Гэвч Монгол Улсын хэмжээнд 2019 онд агаарын хэмийн халалт, бороо хур ороогүйгээс шалтгаалан ган болж газар тариалангийн бүс нутгуудаар ургац алдсанаас зарим иргэд, аж, ахуйн нэгж байгууллагууд 2019 оны хаврын тариалалтаар ХХААХҮЯ-ны тариалан эрхлэгчдийг дэмжих сангаар дамжуулан улсын нөөцөөс зээлж авсан үрийн улаан буудайг намрын ургацаас эргүүлэн төлөх бололцоогүй болсон тул улсын нөөцийн барааны авлага 7,624.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаж чадаагүйгээс тайлант онд авлага үүсгэсэн, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй 61.0 сая төгрөгийн зөрчил гаргасан; /Баянхонгор аймгийн ОБХ 30.0 сая, Сэлэнгэ аймгийн ОБХ 18.3 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 2.9 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 1.1 сая, Нийслэлийн онцгой байдлын газар 2.9 сая, Үндэсний аврах бригад 5.8 сая төгрөг/

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд нь авлагын тооцоо үүсгэж бүртгээгүй 44.2 сая төгрөгийн зөрчил гаргасан. / Баян-Өлгий аймгийн ОБХ 4.1 сая, Үндэсний аврах бригад 40.1 сая төгрөг/

2.9.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 368.9 сая, эцсийн үлдэгдэл 230.0 сая төгрөг болж, 138.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	368.9	230.0	- 138.9
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Дүн	368.9	230.0	- 138.9

Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Нийслэлийн онцгой байдлын газрын албан хаагчдын жолоочийн хариуцлагын даатгалын төлбөр болох 9.9 сая төгрөгийг тайлант хугацаанд бөөн дүнгээр нь зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

2.9.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 26,487.9 сая, эцсийн үлдэгдэл 52,159.7 сая төгрөг болж, 25,671.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	9,624.3	34,688.0	25,063.7
Эм боох материал	42.9	64.5	21.6
Дуусаагүй үйлдвэрлэл	18.9	158.7	139.8
Бэлэн бүтээгдэхүүн	386.4	1,305.3	918.9
Хангамжийн материал	16,379.6	15,836.6	- 543.0
Мал амьтад	35.8	41.5	5.7
Биологийн хөрөнгө		65.1	65.1
Дүн	26,487.9	52,159.7	25,671.8

Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 25,671.7 сая төгрөгөөр өсөхөд ОБЕГ-ын хөрөнгө оруулалт, их засварын тайланд Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд хүлээн авсан 30,597.8 сая төгрөгийн тусгай зориулалтын тоног төхөөрөмж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Босго үнээс давсан бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр 166.9 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн; /Говь-Алтай аймгийн ОБХ 17.8 сая, Дорнод аймгийн ОБХ 149.1 сая төгрөг/
- Шатахууны анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарцуулалтын тооцоог нормоор бодож баримтжуулаагүй, шатахууны урамшууллыг бүртгэж тайлагнаагүй нийт 53.3 сая төгрөг байна; /Дундговь аймгийн ОБХ 18.8 сая, Дорнод аймгийн ОБХ 10.3 сая, Завхан аймгийн ОБХ 7.7 сая, Говь-Алтай аймгийн ОБХ 1.8 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 8,3 сая, Үндэсний аврах бригад 6.4 сая төгрөг/
- Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын хэлтэс төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 28.6 сая төгрөгийн хэрэглээний нүүрс нөөцөлсөн;
- Дундговь аймгийн Онцгой байдлын хэлтэс батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй 13.4 сая төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан;

2.9.5 НӨӨЦИЙН БАРАА

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 72,540.8 сая, эцсийн үлдэгдэл 74,161.3 сая төгрөг болж, 1,620.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нөөцийн барааны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	33,031.0	34,206.5	1,175.5
Үрийн нөөц	6,201.6	3,576.7	- 2,624.9
Тэжээлийн нөөц	10,905.8	11,038.2	132.4
Шатахууны нөөц	19,932.7	23,953.7	4,021.0
Буудайн нөөц	81.0	54.3	- 26.7
Бусад нөөц	2,388.7	1,331.9	- 1,056.8
Дүн	72,540.8	74,161.3	1,620.5

Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 26,146.5 сая, эцсийн үлдэгдэл 29,687.9 сая төгрөг болж, 3,541.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	99,225.8	96,944.3	- 2,281.5
Авто тээврийн хэрэгсэл	28,812.1	31,874.4	3,062.3
Машин тоног төхөөрөмж	7,558.8	5,493.9	- 2,064.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,241.3	1,364.3	123.0
Зам, гүүрийн байгууламж	84.0	70.2	- 13.8
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	174.3	117.6	- 56.7
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3.4	3.4	-
Бусад хөрөнгө	773.7	710.5	-63.2
Дуусаагүй барилга	2,373.8	4,048.3	1,674.5
Ном	3.0	3.0	-
Биет хөрөнгийн дүн	140,250.2	140,629.9	379.7
Программ хангамж	19.8	22.7	2.9
Бусад биет бус хөрөнгө	26,126.7	29,665.2	3,538.5
Биет бус хөрөнгийн дүн	26,146.5	29,687.9	3,541.4
Үндсэн хөрөнгийн дүн	166,396.7	170,317.8	3,921.1

Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 3,921.1 сая төгрөгөөр өсөхөд ОБЕГ-ын хөрөнгө оруулалт, их засварын тайланд Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд хүлээн авсан тусгай зориулалтын машины өртөг голлох нөлөө үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/15 дугаар тушаалаар нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй гал унтраах тусгай зориулалтын автомашин, үүргийн гал унтраагуур, үлээгч аппарат зэрэг 4 нэр төрлийн 572.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 2016 онд акт үйлдэн өгч Дотоод хэргийн их сургуульд ашиглагдаж байна;
- Биетээр байхгүй 29.9 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасан; /Багахангай дүүргийн ОБХ 2.1 сая, Нийслэлийн онцгой байдлын газар 27.8 сая төгрөг/
- Хан-Уул дүүргийн онцгой байдлын хэлтэс жилийн эцсийн илтгэх хуудасны дүнг санхүүгийн байдлын тайланд тусгасан үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 38.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Худалдан авсан болон ОБЕГ-аас хуваарилсан Ланд-200 автомашиныг ТӨБЗГ-ын зөвшөөрөл ирээгүй гэсэн шалтгаанаар орлогод аваагүй; /Баян-Өлгий аймгийн ОБХ, Говь-Алтай аймгийн ОБХ/
- Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үндсэн хөрөнгийн дансанд газрыг давхардуулан бүртгэсэн;
- Төв аймгийн Онцгой байдлын хэлтсийн шуурхай удирдлагын автомашин худалдан авахад дэмжлэг үзүүлэх тендер шалгаруулалтыг аймгийн Орон нутгийн өмчийн газар цахимаар 40.0 сая төгрөгийн өртөгтэйгээр зохион байгуулахад оролцогч ирээгүй тул шууд гэрээ байгуулах эрхийг захиалагчид олгосноор иргэнтэй 76.3 сая төгрөгөөр автомашин нийлүүлэх гэрээ байгуулсан;
- Аврагч биеийн тамир, техник-спортын хороо босго үнээс давсан бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр 13.1 сая төгрөгийн тавилгын шууд худалдан авалт хийсэн;
- Онцгой байдлын ерөнхий газар автомашины гаалийн татварт төлсөн 7.6 сая төгрөгөөр тухайн хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж бүртгээгүй;
- Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй, хорогдлоороо өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй программ хангамжийг данснаас хасаагүй. /Баянхонгор аймгийн ОБХ, Дорнод аймгийн ОБХ, Баян-Өлгий аймгийн ОБХ/

2.9.7 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6,114.5 сая, эцсийн үлдэгдэл 1,072.7 сая төгрөг болж, 5,041.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	5,944.1	1,014.2	- 4,929.9
Ажилчидтай холбогдсон өглөг	3.0	18.0	15.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4.8	64.3	59.5
Бусад өглөг	5,936.3	931.9	- 5,004.4
Урьдчилж орсон орлого	170.4	58.5	- 111.9
Нийт өр төлбөрийн дүн	6,114.5	1,072.7	- 5,041.8

Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр өмнөх оноос 5,041.8 сая төгрөгөөр буурсан нь 2018-2019 онд тэтгэвэрт гарсан албан хаагчдад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн 4,984.8 тэрбум төгрөгийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна..

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаж чадаагүйгээс тайлант онд өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй 19.5 сая төгрөгийн зөрчил гаргасан. /Говь-Алтай аймгийн ОБХ 0.2 сая, Баян-Өлгий аймгийн ОБХ 0.4 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 0.6 сая, Үндэсний аврах бригад 15.1 сая, Улсын нөөцийн объект 3.2 сая төгрөг/

2.9.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 264,262.9 сая, эцсийн үлдэгдэл 307,450.4 сая төгрөг болж, 43,187.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	87,293.2	90,719.2	3,426.0
Хуримтлагдсан үр дүн	125,047.1	164,825.3	39,778.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	51,922.6	51,905.9	- 16.7
Дүн	264,262.9	307,450.4	43,187.5

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

“Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу 2018 онд газрыг дахин үнэлж, бүртгэхэд гарсан 3,441.7 сая төгрөгийн алдааг залруулснаас шалтгаалан засгийн газрын оруулсан капитал данс өмнөх оноос нэмэгдсэн.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 100,772.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 91,048.9 сая төгрөгийг урсгал зардалд, 9,723.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 96,108.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 4,663.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 92,363.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 97,139.1 сая төгрөгийг зарцуулж 96.4 хувийн биелэлттэй, 3,635.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 4,775.4 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 111.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймаг, сумдад шинээр байгуулагдаж байгаа Онцгой байдлын хэлтсүүдийн үйл ажиллагаа эхлээгүйтэй холбоотойгоор нэгдсэн төсвийн гүйцэтгэл нийт 3,633.7 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Үүнд:

- Цалин НДШ-ийн зардал 2,863.5 сая төгрөгөөр;
- Байр ашиглалтын зардал 203.6 сая төгрөгөөр;
- Нормын хувцас 58.8 сая төгрөгөөр;
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, батлагдсан төсвөөс 441.3 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс тус тус шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 9,723.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 9,282.5 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт олгож, 359.1 сая төгрөгөөр биет болон биет бус хөрөнгө худалдан авч, 82.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандивын дансанд "Швейцарын хөгжлийн агентлаг"-аас 330.6 сая төгрөг, бусад хандивлагчдаас 185.8 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 6,259.5 сая төгрөг, Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас 1,916.9 сая төгрөг, нийт 8,692.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Бараа, ажил үйлчилгээний зардалд 7306.4 сая, тэтгэмж, урамшуулал, шагналын зардалд 1038.5 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 82.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Онцгой байдлын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

2019 оны завсрын аудитаар өгсөн 0.3 сая төгрөгийн зөрчил арилгах төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй боловч 18.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснийг 71.4 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНБООУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Онцгой байдлын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

ОБЕГ-ын харьяа Улсын нөөцийн объект 3, Аврагч биеийн тамир, техник спортын хороо, Хүнсний нөөцийн салбар, Шатахууны нөөцийн салбар, Гамшиг судлалын хүрээлэн, Давтан сургалт сэргээн заслын төв цахим төлбөрийн баримтгүй /e-баримт/ худалдан авалт хийсэн нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцээгүй байна..

3.1.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материал, үндсэн хөрөнгө худалдан авах, зардал гаргахдаа цахим төлбөрийн баримтыг хэвлүүлэн авч баримтад хавсаргаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт:

ОБЕГ-ын харьяа Аврагч биеийн тамир, техник спортын хорооны санхүүгийн тайланд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 13.1 сая төгрөгийн тавилгын шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨБАҮХТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт

заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасныг, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая байна гэж заасныг тус тус зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх, төсвийг үр ашиггүй зарцуулах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хууль, журам, дүрэм, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоолыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 ХАРЬЯА ГАЗУУДАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.4.1 Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 38 байгууллагын 41 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 39 санхүүгийн тайлан аудитад хамрагдсан. Аудитаар 68.3 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 600.4 сая төгрөгийн 22 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 507.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 66 зөвлөмж өгсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг үнэлэх, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	103,980,601.0	138,205,297.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	244,033.3	363,705.0
АВЛАГА	4,338,902.2	11,290,589.7
УРЬДЧИЛГАА	368,900.3	230,030.5
БАРАА МАТЕРИАЛ	26,487,980.3	52,159,706.2
НӨӨЦИЙН БАРАА	72,540,784.9	74,161,266.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	166,396,751.7	170,317,825.9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	166,396,751.7	170,317,825.9
Биет хөрөнгө	140,250,204.2	140,629,912.4
Биет бус хөрөнгө	26,146,547.5	29,687,913.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	270,377,352.7	308,523,123.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,114,472.3	1,072,721.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,114,472.3	1,072,721.8
Өглөг	5,944,056.7	1,014,177.8
Урьдчилж орсон орлого	170,415.6	58,544.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	264,262,880.4	307,450,401.9
Засгийн газрын хувь оролцоо	264,262,880.4	307,450,401.9
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	87,293,169.1	90,719,170.1
Хуримтлагдсан үр дүн	125,047,093.4	164,825,277.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	51,922,617.9	51,905,954.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	270,377,352.7	308,523,123.7

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	126,145,901.7	155,289,074.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,498,084.2	51,306,582.7
Нийтлэг татварын бус орлого	27,498,084.2	51,306,582.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,647,817.5	103,982,491.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	133,150,829.1	115,198,736.6
УРСГАЛ ЗАРДАЛ	118,682,877.3	105,012,780.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,767,275.5	98,352,234.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,384,120.8	54,906,850.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,515,256.5	1,609,210.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,572,312.2	3,915,405.7
Хангамж, бараа материалын зардал	4,871,196.7	4,495,826.3
Нормативт зардал	5,826,690.4	3,328,700.7
Эд хогшил, урсгал засварын зардал	3,449,978.7	2,132,573.2
Томилолт, зочны зардал	1,664,709.5	2,333,530.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,211,860.3	3,752,434.5
Бараа үйлчилгээний бусад зардал	31,271,150.3	21,877,701.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,915,601.8	6,660,546.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,467,951.8	10,185,955.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-7,004,927.3	40,090,337.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	3,110.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,962,768.7	440,114.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-16,967,696.06	39,653,333.4

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	108,083,248.8	110,328,581.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,222,150.4	5,732,033.2
Нийтлэг татварын бус орлого	7,222,150.4	5,732,033.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	100,861,098.3	104,596,547.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,110,512.5	100,217,011.6
УРСГАЛ ЗАРДАЛ	97,110,512.5	100,217,011.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,767,840.4	88,472,098.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,365,319.0	54,750,266.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,536,376.8	1,604,495.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,695,553.5	3,921,029.5
Хангамж, бараа материалын зардал	2,946,556.9	2,719,137.3
Нормативт зардал	4,090,753.3	4,570,132.3
Эд хогшил, урсгал засварын зардал	1,453,624.2	3,472,516.9
Томилолт, зочны зардал	1,570,419.9	1,882,321.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,532,482.9	5,156,781.7
Бараа үйлчилгээний бусад зардал	16,576,753.9	10,395,418.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,342,672.1	11,744,912.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,972,736.3	10,111,569.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,845,506.0	9,991,897.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,845,506.0	9,991,897.7
Дотоод эх үүсвэрээр	10,845,506.0	9,991,897.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,845,506.0	-9,991,897.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	127,230.3	119,671.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	116,803.0	244,033.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	244,033.3	363,705.0

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	217,158,762.7	0.0	217,158,762.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,084,575.2	0.0	-1,084,575.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	216,074,187.5	0.0	216,074,187.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	38,461,433.1	0.0	38,461,433.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	26,694,955.9	0.0	26,694,955.9
Тайлант үеийн үр дүн	-16,967,696.1	0.0	-16,967,696.1
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,262,880.4	0.0	264,262,880.4
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	264,262,880.4	0.0	264,262,880.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,550,851.9	0.0	3,550,851.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	267,813,732.2	0.0	267,813,732.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-16,663.8	0.0	-16,663.8
Тайлант үеийн үр дүн	39,653,333.4	0.0	39,653,333.4
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,450,401.8	0.0	307,450,401.8

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,772,730.4	97,139,062.4	3,633,668.0	96.39
УРСГАЛ ЗАРДАЛ	91,048,888.2	87,856,578.7	3,192,309.5	96.49
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,682,206.7	80,490,689.4	3,191,517.3	96.19
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,714,862.5	54,441,654.3	2,273,208.2	95.99
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,165,364.3	1,575,026.5	590,337.8	72.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,000,426.0	3,796,805.3	203,620.7	94.91
Хангамж, бараа материалын зардал	2,212,188.2	2,210,726.6	1,461.6	99.93
Нормативт зардал	4,245,600.3	4,186,801.5	58,798.8	98.62
Эд хогшил, урсгал засварын зардал	3,114,385.0	3,114,165.3	219.7	99.99
Томилот, зочны зардал	86,034.7	85,569.7	465.0	99.46
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,268,092.1	10,205,088.8	63,003.3	99.39
Бараа үйлчилгээний бусад зардал	875,253.6	874,851.5	402.1	99.95
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,366,681.5	7,365,889.3	792.2	99.99
Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,600.0	55,600.0	0.0	100.00
Бусад урсгал шилжүүлэг	7,311,081.5	7,310,289.3	792.2	99.99
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,723,842.2	9,282,483.7	441,358.5	95.46
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	100,772,730.4	97,138,551.6	3,634,178.8	96.39
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	96,108,899.2	92,363,090.5	3,745,808.7	96.10
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,663,831.2	4,775,461.1	-111,629.9	102.39
БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.04	0.04	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	4.82	4.49	0.33	93.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,738,592.2
УРСГАЛ ЗАРДАЛ	8,344,978.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,306,452.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,434.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,283.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,507.5
Хангамж, бараа материалын зардал	417,630.9
Нормативт зардал	151,888.4
Эд хогшил, урсгал засварын зардал	662,702.8
Томилолт, зочны зардал	1,795,001.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-5,088,648.5
Бараа үйлчилгээний бусад зардал	9,259,652.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,038,526.3
Бусад урсгал шилжүүлэг	956,309.2
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,217.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	393,613.9
Дотоод эх үүсвэрээр	393,613.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,692,917.8
Нэмэлт санхүүжилтийн орлого	8,692,917.8
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-45,674.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,674.4

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.20	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/03/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Улсын нөөцийн объект 3 нь ажилтанд олгосон хоол, унааны нөхөн олговор 32.6 сая төгрөгийг татварт тайлагнаагүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байна.	32.6	Албан шаардлага	Улсын нөөцийн объект 3 салбарын дарга Нягтлан бодогч	Б.Ганбат С.Өлзийбаатар
2	ОБЕГ-ын харьяа Улсын нөөцийн объект 3, Аврагч биеийн тамир, техник спортын хороо, Хүнсний нөөцийн салбар, Шатахууны нөөцийн салбар, Гамшиг судлалын хүрээлэн, Давтан сургалт сэргээн заслын төв цахим төлбөрийн баримтгүй /е-баримт/ худалдан авалт хийсэн байна.	0	Зөвлөмж өгөх	ОБЕГ-ын дарга	
3	Онцгой байдлын ерөнхий газрын харьяа газруудын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 10,134.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 8,958.0 сая төгрөгийн алдааг залруулж 68.3 сая төгрөгийн акт тогтоож, 600.4 сая төгрөгийн албан шаардлага, 507.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.	1,176.4	Харьяа газруудад илэрсэн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх, талаар анхаарч ажиллах зөвлөмж өгөх	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн	Т.Бадрал Г.Бат-Эрдэнэ Н.Бадамханд
4	ОБЕГ-ын харьяа Аврагч биеийн тамир, техник-спортын хорооны санхүүгийн тайланд ХАА зохион байгуулаагүй 13.1 сая төгрөгийн тавилгын шууд худалдан авалт хийсэн байна.	13.1	Зөвлөмж өгөх		

5	<p>Онцгой байдлын ерөнхий газрын 2016 оны А/15 дугаар тушаалаар нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй гал унтраах тусгай зориулалтын автомашин, үүргийн гал унтраагуур, үлээгч аппарат зэрэг 4 нэр төрлийн 572.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 2016 онд акт үйлдэн хүлээлгэн өгсөн байна. Дээрх хөрөнгө нь ямар нэгэн тогтоол шийдвэргүйгээр Дотоод хэргийн их сургуульд ашиглагдаж байна.</p>	572.6	Албан шаардлага	<p>ОБЕГ-ын дарга</p> <p>Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч</p> <p>Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн</p>	<p>Т.Бадрал</p> <p>Г.Бат-Эрдэнэ</p> <p>Н.Бадамханд</p>
	Нийт дүн	1,794.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/186

Улаанбаатар хот

САГ-2020/03/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/15 дугаар тушаалаар Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй гал унтраах тусгай зориулалтын автомашин, үүргийн гал унтраагуур, үлээгч аппарат зэрэг 4 нэр төрлийн 572.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Дотоод хэргийн их сургуульд ашиглуулахаар хүлээлгэн өгсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Төрийн байгууллага, албан газар ... нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй:" 2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тусгай зориулалтын 572.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг хууль, журмын дагуу шийдвэрлэх, холбогдох арга хэмжээ авах;
2. Байгууллага хооронд хөрөнгө шилжүүлэн ашиглуулахдаа холбогдох эрх бүхий байгууллагын тушаал, шийдвэрийн дагуу шийдвэрлэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх;
3. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 09 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, хурандаа Г.Бат-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
ӨГСӨН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ АХЛАХ АУДИТОР Б.СЭРЖМЯДАГ АУДИТОР А.ДАВААДОРЖ	ЗӨВШӨӨРСӨН: ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ, ХУРАНДАА Г.БАТ-ЭРДЭНЭ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтныг хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichir_Kheree\Alban_Shaardлага\2020\03\25\САГ20.Docx

001080648



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25 № 01/185
САГ-2020/03/СТА-ТТЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Улсын нөөцийн объект 3 нь ажилтанд олгосон хоол, унааны нөхөн олговор 32.6 сая төгрөгийг татварт тайлагнаагүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан 2006 оны Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3."Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ" гэж заасныг, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 "Суутгагч нь энэ хуулийн 8.1.7, 8.1.8, 11 дүгээр зүйл, 13.1.2-13.1.4, 14.1.1, 15 дугаар зүйлд заасны дагуу суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд ирүүлнэ", 2019 оны Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажилчин, албан хаагчдад олгосон 32.6 сая төгрөгийн хоол, унааны мөнгийг харьяа татварын албанд нөхөн тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 09 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, хурандаа Г.Бат-Эрдэнэ нарт хариуцуулав.

<p>ӨГСӨН: САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР И.НАРАНЧИМЭГ АХЛАХ АУДИТОР АУДИТОР Б.СЭРЖМЯДАГ А.ДАВААДОРЖ</p>	<p>АЛБАН ШААРДЛАГЫГ</p> <p>ЗӨВШӨӨРСӨН: УЛСЫН НӨӨЦИЙН ОБЪЕКТ 3 САЛБАРЫН ДАРГА, ХОШУУЧ Б.ГАНБАТ НЯГТЛАН БОДОГЧ, АХЛАХ ДЭСЛЭГЧ С.ӨЛЗИЙБААТАР</p>
---	---

Акт, албан шаардлагын биелэлийг хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь хэзэх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанг хариуцахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichir_Kherep\Alban Shaardлага\2020\03\55\САГ19.Docx

001080641

